

## ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

Дотоод аудитын дугаар: 03

Огноо: 2025 оны 06 дугаар 06

Аудитын зорилго: ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо зохих журмын дагуу зөв хэрэгжиж мөрдөж байгаа эсэх

Аудитаар шалгуулагч: Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар

Аудитын шалгуур: ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага стандарт, холбогдох хууль тогтоомж

Аудитын багийн бүрэлдэхүүн: Дотоод аудитын баг

Аудит хийсэн хугацаа: 2025.05.26-2025.06.05

### АУДИТААР ИЛРҮҮЛСЭН ЗҮЙЛС

Том үл тохирол	Жижиг үл тохирол	Анхаарах зүйлс	Сайжруулах зүйлс	Тохирол
			2	24

Илрүүлсэн зүйлсийн ангилал	Илрүүлсэн зүйлсийн дугаар	Илрүүлсэн зүйлийн тодорхойлолт тайлбар	Холбогдох стандартын бүлэг, зүйл заалтын дугаар нар
Том үл тохирол	1		
	2		
	3		
Жижиг үл тохирол	1		
	2		
	3		
Анхаарах зүйлс	1		
	2		
	3		
Сайжруулах зүйлс	1	Чанарын бодлогыг мэдэж байгаа эсэх	7.3
	2	Чанарын зорилтуудыг мэдэж байгаа эсэх	7.3
	3		

### ДҮГНЭЛТ

Чанарын менежментийн тогтолцооны 6 дугаар бүлэг болох “Төлөвлөлт” бүлгийн хүрээнд:

6.2 Чанарын зорилтуудад хүрэхэд чиглэсэн төлөвлөлт

6.3 Өөрчлөлтийг төлөвлөх

зэрэг хоёр дэд бүлгийн хүрээнд 12 шалгуур үзүүлэлтээр дотоод аудит хийгдсэн бөгөөд 12 үзүүлэлт бүгд тохиролтой гэж үнэлэгдсэн.

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар нь чанарын менежментийн тогтолцооны хүрээнд төлөвлөсөн зорилтуудын хэрэгжилтийг шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр тусгасан. 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтээс дүгнэлт хийж, шаардлагатай сайжруулалтын арга хэмжээг тодорхойлсны үндсэн дээр 2025 оны төлөвлөгөөнд тусган, холбогдох сайжруулалтуудыг хийсэн байна.

Чанарын зорилтууд нь чанарын бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн бөгөөд уг бодлоготой уялдсан. Зорилтууд нь чанарын болон тоон үзүүлэлтээр хэмжигдэхүйц байдлаар төлөвлөгдсөн. Мөн хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаанд үндэслэн үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээг тодорхойлсон байна.

Тамгын газар нь чанарын зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийн явцыг тухай бүр тайлагнаж мэдээлдэг. Мөн чанарын менежментийн тогтолцоонд өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд, тухайн өөрчлөлт хийх зорилго, түүгээр бий болох боломжит үр дагавар, шаардагдах нөөцийн бэлэн байдал, эрх мэдлийн дахин хуваарилалтыг тодорхойлох шаардлагатай гэж тусгасан. Гэвч одоогийн байдлаар тогтолцоонд өөрчлөлт оруулах шаардлага гараагүй байна.

Чанарын менежментийн тогтолцооны 6 дугаар бүлэг болох “Төлөвлөлт” бүлгийн хүрээнд:

#### 7.1.3. Дэд бүтэц

#### 7.1.4. Үйл явцыг хэрэгжүүлэх орчин

7.3. Мэдлэг ойлголт Байгууллага нь өөрийн хяналтан дор ажиллаж байгаа ажилтнуудад дараах зүйлийг мэдүүлж ойлгуулна. Үүнд:

7.4. Холбоо харилцаа. Дотоод болон гадаад харилцаа холбооны асуудлыг тодорхойлох

зэрэг дөрвөн дэд бүлгийн хүрээнд 14 шалгуур үзүүлэлтээр дотоод аудит хийгдсэн бөгөөд 12 үзүүлэлт тохиролтой, 2 сайжруулах асуудал илэрсэн.

Чанарын бодлогыг албан хаагчид мэдэж байгаа эсэх талаар түүврийн аргаар асуулга авахад ТЗУХ-3, ХЭЗХ-2, СТСХ-1, НҮА-2, ТАСЗ-1 албан хаагч тус тус оролцсоноос мэдэхгүй гэж хариулсан 1, чанарын бодлогыг дутуу буюу өөрсдийн үгээр бичсэн 8 албан хаагч байв.

Чанарын зорилтыг албан хаагчид мэдэж байгаа эсэх талаар түүврийн аргаар авсан судалгаанд ТЗУХ-3, ХЭЗХ-2, СТСХ-1, НҮА-2, ТАСЗ-1 албан хаагч тус тус оролцсоноос нийт 8 зорилтоос 4 зорилтыг зөв бичсэн 4, 6 зорилтыг зөв бичсэн 2, 8 зорилтыг зөв бичсэн 2 албан хаагч байв.

## ХАВСРАЛТУУД

Материалын нэр	Хуудасны тоо	Тэмдэглэгээ
Шалгах хуудас:	2	
Үл тохирлын тайлбар	-	
Нотолгоо	-	
Нийт хавсралтын тоо:	2	